




БИ
ГАЙХАМШИГТ
ИТГЭДЭГГҮЙ

БИ БЕРЕШД
ИТГЭДЭГ

ДОКТОР ЙОЖЕФ БЕРЕШ (1920-2006)



Доктор Йожеф Береш (1920-2006) нь Унгарын шинжлэх ухааны түүхэнд домогт нэгэн юм. Тэрбээр 1972 онд Береш дуслыг бүтээсэн нь одоо ч Унгарын эрүүл мэндийг хамгаалах болон эмчилгээний бүтээгдэхүүнүүдийг манлайлж байна.

Социализмын үед тэрбээр шинэлэг санаануудаасаа болж хууран мэхлэгч гэгдэж, нийгэм солигдож нээлтийг нь хүлээн зөвшөөрөх хүртэл маш олон бэрхшээлийг даван туулж, дарамт шахалтад өртөж байжээ. Береш компаниа байгуулснаас хойш бүтээгдэхүүн тэр даруй нэр хүндийг олж одоо ч тэр нэр хүндээ хадгалсаар байна.

Доктор Йожеф Береш өөрийн мэдлэг, хичээл зүтгэл, хүнлэг сэтгэлгээнийхээ дүнд өндөр хүндлэл олж авсан ба 2002 онд Унгарын шинжлэх ухааны хамгийн өндөр шагнал болох Сечений шагналыг Береш дуслыг зохион бүтээснийхээ төлөө авчээ.

УНГАР ЗОХИОН БҮТЭЭГЧИЙН ДОМОГТ НЭЭЛТ

- Хагас зууны өмнө суут судлаач Доктор Йожеф Береш ижил нөхцөлд хоёр өөр хөрсөнд ургуулсан ургамлуудад ургалт ба үр жимсний чанар нь ондоо байгааг анзаарсан байна. Доктор Берешийн энэхүү ажиглалт нь яагаад ийм ялгаа байна вэ гэдгийг судлахад хүргэсэн. Ургамлуудад зөвхөн ганц хүчин зүйл нь ондоо байсан ба үүнд судалгаагаа суурилсан нь хөрс байлаа.
- Маш олон судалгаа шинжилгээний үр дүнд тэрбээр үржил шим муутай хөрс нь организмд чухал шаардлагатай зарим тэжээлээр дутмаг байгааг олж илрүүлсэн ба эдгээрийг хөрсөнд нэмсний дараа ургамал өвчлөлгүй эрүүл ургасан байна. Үүнээс үүдэн маш олон жилийн судалгааны үр дүнд микроэлементүүдийн организм дахь орлуулшгүй үүргийн тухай олж нээснээр хүний бие махбодид явагдаж буй биохимийн урвалуудад микроэлементүүд зайлшгүй хэрэгтэй гэсэн өнөөгийн ойлголтод хүрэх замыг нээж өгсөн юм. Микроэлементүүдийг хүний биед хэрэгцээтэй хэмжээгээр нь хольж тусгай аргаар бие мах бодид шууд шингэхээр бэлтгэгдсэн нэгдэл бол өнөөдрийн Береш дусал юм.

БЕРЕШ ДУСАЛ ТҮҮХИЙН ХЭЛХЭЭ

Доктор Йожеф Береш микроэлементээс бүрдсэн эмчилгээний болон урьдчилан сэргийлэх нэгэн бэлдмэл нээсэн бөгөөд хожим нь Береш гэж нэрлэсэн байна

1972

Береш дусал патент албан ёсоор авсан

1976

Береш дусал худалдаанд гарсан

1978

Береш фарма эмийн үйлдвэр үүсгэн байгуулагдсан

1989

Доктор Йожеф Береш 2002 онд Унгарын шинжлэх ухааны хамгийн өндөр шагнал болох Сечений шагналыг Береш дуслыг зохион бүтээснийхээ төлөө авчээ.


2002

- <https://youtu.be/3SLlvU0juc0>

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАГААН ТОЛГОЙ

“Ямар нэг өвчин болон эмгэг үүсвээс хариуг нь микроэлементийн дутагдлаас хайгаарай”

Лайнус Карл Полинг
Нобелийн 2 удаагийн шагналт, доктор
АНУ-ын химич, минеролог



Байгальд тааралддаг 92 элементээс 81 хүний организмд байдаг.

Макроэлемент-нүүрстөрөгч, устөрөгч, хүчилтөрөгч, азот, кальци, фосфор, кали, хүхэр, хлор, натри, магни.

Микроэлемент-төмөр, иод, зэс, цайр, кобальт, хром, молибден, селен, манган, фтор.

Периодическая таблица Д. И. Менделеева

Период	Ряд	ГРУППЫ ЭЛЕМЕНТОВ																			
		I	II	III	IV	V	VI	VII	VIII												
1	1	(H)															H 1,00797 Водород	He 4,0026 Гелий	Обозначение элемента	Атомный номер	
2	2	Li 6,909 Литий	Be 9,0122 Бериллий	B 10,811 Бор	C 12,01115 Углерод	N 14,0067 Азот	O 15,9994 Кислород	F 18,9984 Фтор	Ne 20,179 Неон										Li 6,909 Литий	3	
3	3	Na 22,9898 Натрий	Mg 24,305 Магний	Al 26,9815 Алюминий	Si 28,086 Кремний	P 30,9738 Фосфор	S 32,064 Сера	Cl 35,453 Хлор	Ar 39,948 Аргон											Относительная атомная масса	
4	4	K 39,102 Калий	Ca 40,08 Кальций	Sc 44,956 Скандий	Ti 47,88 Титан	V 50,942 Ванадий	Cr 51,995 Хром	Mn 54,938 Марганец	Fe 55,847 Железо	Co 58,933 Кобальт	Ni 58,71 Никель										
	5	Cu 63,546 Медь	Zn 65,37 Цинк	Ga 69,72 Галлий	Ge 72,59 Германий	As 74,9216 Мышьяк	Se 78,96 Селен	Br 79,904 Бром	Kr 83,80 Криpton												
5	6	Rb 85,47 Рубидий	Sr 87,62 Стронций	Y 88,905 Иттрий	Zr 91,22 Цирконий	Nb 92,906 Нобий	Mo 95,94 Молибден	Tc [98] Технеций	Ru 101,07 Рутений	Rh 101,905 Родий	Pd 106,4 Палладий										
	7	Ag 107,868 Серебро	Cd 112,40 Кадмий	In 114,82 Индий	Sn 118,69 Олово	Sb 121,75 Сурьма	Te 127,60 Теллур	I 126,9044 Йод	Xe 131,29 Ксенон												
6	8	Cs 132,905 Цезий	Ba 137,34 Барий	La* 138,91 Лантан	Hf 178,49 Гафний	Ta 180,948 Тантал	W 183,85 Вольфрам	Re 186,2 Рений	Os 190,2 Осмий	Ir 192,22 Иридий	Pt 195,09 Платина										
	9	Au 196,967 Золото	Hg 200,59 Ртуть	Tl 204,37 Таллий	Pb 207,19 Свинец	Bi 208,980 Висмут	Po [210]* Полоний	At [210] Астат	Rn [222] Радон												
7	10	Fr [223] Франций	Ra [226] Радий	Ac** [227] Актиний	Rf [261] Рендерфордий	Db [262] Дубний	Sg [263] Сяборгий	Bh [264] Бергий	Hs [265] Хассий	Mt [266] Мейтнерий	Ds [271] Дармштадтий										
	11	Rg [272] Рентгий	Cn [285] Кловергий	Nh [286] Нихоний	Fl [288] Флеровий	Mc [289] Московский	Lv [292] Ливерморий	Ts [294] Теннесси	Og [294] Оганессон												

58	Ce 140,12 Церий	Pr 140,907 Прометий	Nd 144,24 Неодим	Pm [147]* Прометий	Sm 150,36 Самарий	Eu 151,96 Европий	Gd 157,25 Гадолиний	Tb 158,925 Тербий	Dy 162,50 Диспрозий	Ho 164,9303 Гольмий	Er 167,26 Ербий	Tm 168,934 Тульий	Yb 173,04 Иттербий	Lu 174,967 Лютеций
90	Th 232,038 Торий	Pa [231] Протактиний	U 238,03 Уран	Np [237] Нептуний	Pu [244] Плутоний	Am [243] Америций	Cm [247] Кюрий	Bk [247] Беркелий	Cf [251] Калифорний	Es [252] Эйнштейний	Fm [257] Фермий	Md [261] Менделеев	No [259] Нобелий	Lr [260] Лоренций

- Микроэлементүүд нь биеийн бүх шингэн, эд эсийн бүтцэд ордог.
- Булчин, зүрх судасны, дархлааны, мэдрэлийн болон бусад системийн хэвийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай;
- Амьдралын амин чухал нэгдлүүдийн нийлэгжилт, бодисын солилцооны үйл явц, цус үүсэх, хоол боловсруулах, бодисын солилцооны бүтээгдэхүүнийг саармагжуулахад оролцоно
- Зарим дааврын найрлагад ордог.(жишээлбэл, иод - тироксин, цайр - инсулин ба бэлгийн даавар), эдгээрийн үйл ажиллагааг тодорхойлдог. Ферментийн хурдасгуур (зэс, цайр, манган, кобальт)
- Микроэлементүүд нь бусад витамин, фермент, гармоноос ялгаатай нь организмд нийлэгждэггүй. Зөвхөн хоол тэжээлээр, ус, агаараас авах боломжтой байдаг бөгөөд 15-20 % нь шингэдэг

■ *Микро болон макроэлементийн дутагдал*

-Өсөлтийн үедээ яваа хүүхэд,

-Өсвөр насныхан,

-Өндөр настнууд,

-Жирэмсэн эмэгтэйчүүд,

-Хөхүүл эхчүүд,

-Ходоод гэдэсний замын архаг өвчтэй хүмүүс /дисбиоз/

-Тамирчид

-Мэс заслын дараах нөхөн сэргээлтийн үеийн өвчтөнүүдэд илүү мэдрэмтгий байдаг.

Хэзээ мэдэгдэх вэ?

-Эрүүл хүний хувьд бие махбодын хэт их ачаалал,

-Тэнцвэргүй хоол тэжээл,

-Тогтмол стресс,


-Намар-өвөл, Өвөл-хаврын шилжилтийн үед ажиглагддаг.

Шаардлагатай микроэлементийг
хангалттай хэмжээгээр зөв харьцаатайгаар
агуулсан усан уусмал- Береш 30, 100 мл.

Найрлагад төмөр, цайр, манган, зэс,
молибден, селен, хром, фтор агуулагдана.



ТӨМӨР



Бие махбодын үйл ажиллагаанд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг.
-эсэд амьсгалын үйл явцыг хангадаг гемоглобин, зарим нэг ферментийг (пероксидаза, цитохром оксидаза гэх мэт) үүсэхэд оролцдог ;
-аскорбины хүчлийн оролцоотой явагддаг ихэнх биокатализийн процесст оролцдог
- эсийн ялгаатай байдал, өсөлтийн чухал хүчин зүйл
-дархлааны эсийн үйл ажиллагаанд шаардлагатай ферментийн хурдасгуур

Олон тооны судалгаагаар төмрийн дутагдал нь дархлааны чадваргүй эсүүдийн ажилд чухал нөлөө үзүүлдэг.

ТӨМӨР

- ДЭМБ-ын мэдээлснээр дэлхийд 4 тэрбум орчим хүн янз бүрийн түвшинд төмрийн дутагдалтай гэсэн судалгаа байдаг
- Төмрийн дутагдалтай үед Т-лимфоцитын нийт тоо буурч, идэвхжүүлсэн лимфоцитаас ялгардаг интерлейкин буурдаг
- Төмрийг зэс, цайрыг хамтдаа хэрэглэхэд бие биеийхээ үйлдлийг дэмждэг

ЦАЙР

Өнөө үед эр бэлгийн булчирхайн хэвийн үйл ажиллагааг хангах, хадгалахад цайр оролцдог гэдгийг баталсан бөгөөд цайрын дутагдлын үед хөвгүүдэд бэлгийн бойжилт хожуу явагдах шинж тэмдэг илрэхээс гадна эрэгтэйчүүдэд бэлгийн сулрал, түрүү булчирхайн хавдар илэрдэг.

Цайрын дутагдлын үед хэт мэдрэг болох, ядрах, нойргүйдэл, сэтгэлийн хямрал, хоолны дуршил буурах, арьсны тууралт, батга, шархны эдгэрэлт удаашрах, үс унах, хумс хугарах болон хумсан дээр цагаан толбо гарах, жирэмсэн эмэгтэйчүүд дутуу төрөх зэрэг юм.



ЦАЙР

- Дархлаатай хэрхэн холбогддог талаар хангалттай нотлогдсон. Лимфоцит ба моноцитуудын идэвхтэй байдал нь цайрын агууламжаас ихээхэн хамаардаг
- Бие махбод дахь 70 гаруй ферментийн урвалд оролцдог, уургийн нийлэгжилт, нуклейн хүчлийн солилцоог хангадаг.
- Судалгаанаас үзэхэд байнга өвддөг хүүхдийн 80-90% -д цайрын дутагдал ажиглагддаг. Үүний зэрэгцээ, дархлааны эсийн тоо буурч, зохицуулгын бодис болох тимин, тимозиний ялгаруулалтад нөлөөлөхөөс гадна нейтрофил ба макрофагийн нянгийн эсрэг идэвх буурч, хамгаалалтын эсрэг биеийн ялгаруулалт багасдаг.

БУСАД ЭЛЕМЕНТ

- Манган, зэс, молибден, селен, хром, фтор зэрэг микроэлементүүд нь цайр шиг дархлааны тогтолцоонд тодорхой нөлөө үзүүлэхгүй боловч бусад эрхтэн, тогтолцооны үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай байдаг.
- **Зэс нь** гемоглобины нийлэгжилтэд оролцдог, дархлааны байдалд нөлөөлж, бие махбодын антиоксидант хамгаалалтыг нэмэгдүүлдэг, ферментийг идэвхжүүлдэг (тирозиназа, фенолоксидаз, супероксиддисмутаза).
- **Манган:** антиоксидант үйлдэлд зайлшгүй шаардлагатай ба бусад метаболизмын энзимүүдийн үйл ажиллагаанд оролцоно
- **Селен:** дархлааны системийн зохицуулгад оролцоно
- **Хром:** инсулины үйлчилгээг эрчимжүүлж нүүрс ус болон өөх тосны бодисын солилцоонд чухал үүрэгтэйгээр оролцоно. Булчингийн масс нэмэгдүүлж өөхөн давхаргын массыг бууруулснаар биеийн жин буурахад дэмжлэг үзүүлдэг
- **Молибден:** Хүнд ялангуяа ксантин оксидаз болон сульфит оксидаз энзимүүд нь маш чухал үүрэгтэй молибдоэнзимүүд юм
- **Фтор:** яс болон шүдний метаболизмд оролцдог. Мөн ясны сийрэгжилтийн үед ясны нягтралын нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэдэг

Береш дуслын үйлдэл

- Дархлааны системийг дэмжиж, эрүүл байдлыг хадгална.
- Хагалгаа болон өвчлөлийн дараах эдгэрэлт, тэнхрэлтийг дэмжинэ.
- Бие махбодыг эрчимжүүлнэ.
- Хорт хавдраар өвчилсөн өвчтөний эдгэрлийг түргэсгэнэ.

Береш дуслын хэрэглээ

- Дархлаа дэмжихэд
- Ханиад, томууны үед
- Мэс засал болон гэмтлийн дараа нөхөн сэргээх зорилгоор
- Хавдрын эмчилгээний үеийн хими болон туяа эмчилгээний дараах микроэлементийн алдагдлыг засахад
- Эрүүл мэндийн байдал сул, ядаргаа, сульдаатай үед
- Нойргүйдэх үед
- Хоолны дуршил буурах үед
- Хоолны дэглэм барих үед

ТУН ХЭМЖЭЭ

Урьдчилан сэргийлэх зорилгоор:

- Биеийн жин 10-20 кг жинтэй бол өдөрт 2 удаа 5 дусал
- Биеийн жин 20-40 кг-тай бол өдөрт 2 удаа 10 дусал
- Биеийн жин 40 кг-аас дээш бол өдөрт 2 удаа 20 дусал

Эмчилгээний зорилгоор

- Биеийн жин 10-20 кг-тай бол өдөрт 2 удаа 10 дусал
- Биеийн жин 20-40 кгтай бол өдөрт 2 удаа 20 дусал
- Биеийн жин 40 кг-аас дээш бол өдөрт 3 удаа 20 дуслыг ууна.
- Биеийн жин нь 40 кг-аас дээш байгаа хавдартай өвчтөнд эмчийн зөвлөмжийн дагуу дээрхи тунг нэмэгдүүлж болох боловч өдөрт 120-аас илүү дуслыг хэрэглэж болохгүй. Ийм тохиолдолд өдрийн тунг 4-5 тунгаар тэнцүү хэсэгт хуваахыг зөвлөж байна.

АНХААРУУЛГА

- Хоолтой хамт хэрэглэнэ. Нэг удаагийн тунг 50 мл шингэн (ус, жимсний шүүс, сироп, жимсний цай) дээр нэмэн хэрэглэнэ.
- Энэ эмийг сүү, кофегоор даруулж уухыг зөвлөдөггүй, учир нь энэ нь шингээлтийг бууруулдаг.

Амьдралын төлөө тэмцэх нь үр дүнгээ өгдөг
үүрэг хариуцлага юм.

Доктор Йожэф Береш



■ АНХААРЛААР ШАГНАСАНД
БАЯРЛАЛАА.